



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/256

Улаанбаатар хот

Эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 10 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдалтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн байгууллагын ачаалал, хүн амын тоо, алслагдсан байдал зэргийг харгалзан эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах хуваарь гаргаж, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Эрүүл мэндийг дэмжих төвд сумдын иргэдийг үзлэгт хамруулахыг аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

2. Орон нутгийн иргэдийг эрт илрүүлэгт хамруулан, мэргэжлийн арга зүйгээр хангах төрөлжсөн мэргэшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүнтэй явуулын багийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Хавсралтаар баталсан хуваарийн дагуу эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог хийх багийг томилж ажиллуулахыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, төвийн захирал нарт, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус даалгасугай.

4. Харьяалах хүрээний нутаг дэвсгэрт оршин суугаа оюутан, суралцагчдыг зуны амралтын хугацаанд буюу 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл эрт илрүүлэгт бүрэн хамруулах, үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, 2023 оны 11 дүгээр сард Эрүүл мэндийн сайдын зөвлөлд танилцуулахыг Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд)-т үүрэг болгосугай.

САЙДС.  С.ЧИНЗОРИГ

141224132

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 02
дугаар сарын 12-ны өдрийн 126 дугаар
тушаалын хавсралт

**Эрт илрүүлэгт хамруулан, мэргэжлийн арга зүйгээр хангах
явуулын багийн хуваарь**

Нэг. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллах явуулын багийн хуваарь

№	Хамрагдах аймаг	Хариуцах эрүүл мэндийн байгууллага	Хамтран ажиллах эрүүл мэндийн байгууллага
1.	Говь-Сүмбэр	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Халдварт өвчин судлалын үндэсний төв БОЭТ, Аймгийн нэгдсэн эмнэлэг Сумын Эрүүл мэндийн төв
2.	Дархан-Уул		
3.	Дорноговь		
4.	Дундговь		
5.	Өмнөговь		
6.	Сэлэнгэ		
7.	Төв		
8.	Баян-Өлгий	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Хавдар судлалын үндэсний төв Гэмтэл согог судлалын үндэсний төв БОЭТ, Аймгийн нэгдсэн эмнэлэг Сумын Эрүүл мэндийн төв
9.	Говь-Алтай		
10.	Увс		
11.	Завхан		
12.	Ховд		
13.	Булган		
14.	Орхон		
15.	Дорнод	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв - 2 Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв БОЭТ, Аймгийн нэгдсэн эмнэлэг Сумын Эрүүл мэндийн төв
16.	Сүхбаатар		
17.	Хэнтий		
18.	Архангай		
19.	Баянхонгор		
20.	Өвөрхангай		
21.	Хөвсгөл		

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлд:

“ХII.5.Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаар шийдвэрлэсэн асуудлын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Жендэрийн үндэсний хорооны орлогч дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:


1.Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу Жендэрийн үндэсний хорооны гишүүдийн оролцоонд тулгуурлан дараах арга хэмжээ авч, хэрэгжилтийг танилцуулж ажиллахыг Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанд даалгав:

1.1.Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах арга хэмжээнд эрэгтэйчүүдийг идэвхтэй, бүрэн хамруулж, тэдний амьдралын хэв маягийг зөв хандлагад чиглүүлэх үйл ажиллагааг эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоонд тулгуурлан зохион байгуулах ажлын тусгайлсан төлөвлөгөө гаргаж ажиллах;

1.2.Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласны хүрээнд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх, авлигыг үл тэвчих, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх асуудлаар нийгмийн сэтгэл зүйг зөв хандлагад чиглүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг эмэгтэйчүүдийн оролцоотойгоор зохион байгуулах;

1.3.жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг Улсын Их Хуралд танилцуулах талаар зохих арга хэмжээ авах.

2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Хоёр. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллах явуулын багт дэмжлэг үзүүлэх чиглэл

2.1. Аймаг, сумын Засаг дарга нар дараах чиг үүргийг хүлээнэ. Үүнд:

- Эрт илрүүлгийг зохион байгуулахад харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийг хамруулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган, сумдын удирдлагад үүрэг чиглэлийг урьдчилан өгөх
- Харьяалах нутаг дэвсгэрийн хүрээний эрүүл мэндийн даатгалгүй иргэд (малчин, оюутан, ажил эрхэлдэггүй)-ийг эрүүл мэндийн даатгалд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах
- Явуулын багт дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах, аюулгүй байдлыг хангах
- Явуулын багийн эмч, ажилчдыг амрах байраар хангахад дэмжлэг үзүүлэх

2.2. Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, Сумын эрүүл мэндийн төв дараах чиг үүргийг хүлээнэ. Үүнд:

- Сумдын ирэгдийн эрт илрүүлэгт хамрагдах хуваарийг хариуцсан төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдтэй хамтран гаргаж, холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, харьяалах нутаг дэвсгэрийн иргэдэд мэдээлэл хүргэн, урьдчилан зар түгээх ажлыг зохион байгуулж, үзлэгт хамралтыг нэмэгдүүлэх
- Явуулын багийг ажиллах, орчин нөхцөлөөр хангах
- Эрт илрүүлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, лаборатори, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодисоор хангах
- Шаардлагатай эмч, эмнэлгийн мэргэжилтнийг явуулын багт ажиллуулах
- Эрт илрүүлэгээр илэрсэн өвчлөлийг хяналтад авах, эмчлэх асуудлыг зохион байгуулах

2.3. Явуулын багтай хамтран ажиллах анхан шатны эрүүл мэндийн байгууллага дараах чиг үүргийг хүлээнэ. Үүнд:

- Явуулын багт орж ажиллах хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, лаборатори болон бусад шаардлагатай зүйлсээр хамтарч ажиллах
- Холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, харьяалах нутаг дэвсгэрийн иргэдэд мэдээлэл хүргэн, урьдчилан зар түгээх ажлыг зохион байгуулж, үзлэгт хамралтыг нэмэгдүүлэх
- Явуулын багийг ажиллах, орчин нөхцөлөөр хангах



**МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ АНХ БОЛОН ДАВТАН ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА**

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах эрүүл мэндийн байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
Нэг. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх олгох гадаадын эмнэлгийн мэргэжилтэн								
1	Со Ёну	БНСУ	Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг	-	ГЭ0002755	Нүүр ам судлал	Эмчлэх	4 өдөр /2023.07.16-2023.07.19/
Хоёр. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл давтан олгох гадаадын эмнэлгийн мэргэжилтэн								
1	Годара Нийраж	БНЭУ	Улсын гуравдугаар төв эмнэлэг	-	ГЭ0002756	Гэмтлийн мэс засал судлал	Эмчлэх	6 өдөр /2023.07.24-2023.07.29/
2	Шириваастав Амит	БНЭУ	Улсын гуравдугаар төв эмнэлэг	-	ГЭ0002757	Мэдрэлийн мэс засал судлал	Эмчлэх	6 өдөр /2023.07.24-2023.07.29/